

“УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ
ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 1998 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуулийг батлан, хэрэгжүүлж эхэлснээс хойш 24 жил болж байна.

“Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуулийг хэрэгжүүлж ажиллах явцад холбогдох байгууллага, иргэдээс гаргасан санал, хүсэлтэд үндэслэн уг хуульд 4 удаа өөрчлөлт оруулсан бөгөөд одоо ч өөрчлөлт оруулах хууль зүйн болон нийгмийн шаардлага үүсээд байна.

Цагаатгуулах тухай өргөдөл гомдол хүлээн авах хугацаа 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын чуулганаар батлагдсан нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

Өргөдөл гаргах хугацаа дууссан боловч Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд, Өргөдлийн байнгын хороо, Засгийн газар болон Засгийн газрын холбогдох байгууллага, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн салбар комисст хэлмэгдэгчдийн үр хүүхдүүд, холбогдох төрийн бус байгууллагуудаас “хуулийн хугацаанаас хоцорсон, хэрэг материал олдоогүй, Ковид-19 цар тахалтай холбоотой хэрэгжиж эхэлсэн хууль, дүрэм журмууд нөлөөлсөн” зэрэг нөхцөл байдал, шалтгааны улмаас өөрийн гэр бүлийн төрөл төрөгсдийг цагаатгуулж, нэр төрийг сэргээлгэж чадаагүй гэх олон тооны өргөдөл, гомдол, хүсэлтийг ирүүлсэн байх нь хуулийн хугацааг сунгах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Мөн одоогийн байдлаар 200 орчим иргэн цагаатгуулах тухай өргөдөл гомдлоо гаргаад байна.

Цагаатгуулах тухай гомдол гаргах хуулийн хугацаа дуусгавар болсон тул иргэдээс ирсэн цагаатгуулах тухай өргөдлийг Улсын дээд шүүх, Улсын ерөнхий Прокурор, анхан шатны шүүхүүд хүлээж авахгүй байгаа боловч архивт хадгалагдаж байгаа улс төрийн хилс хэрэгт хамааралтай хэргүүдийг шалган шийдвэрлэх ажиллагаа явагдсаар байгаа юм.

1922 оноос 1990 оныг хүртэл нийтдээ 36,000 орчим хүн улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн тухай баримжаа тоо баримт байдаг бөгөөд одоогийн байдлаар 31,460 иргэн хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр цагаатгагдаад байна.

Нийт хэлмэгдсэн иргэдийн ихэнхийг цагаатгаад байгаа боловч тодорхой нөхцөл байдал, учир шалтгааны улмаас цагаатгуулж амжаагүй иргэдийн эрхийг хуулийн хугацаагаар хязгаарлах нь зохимжгүй бөгөөд эдгээр иргэдэд боломж, бололцоо олгож өгөхийг хүссэн гомдлууд ирсээр байгаа юм.

Иймд Монгол улсын Үндсэн хуульд заасан иргэдийн эрх тэгш байдлыг хангах үүднээс улс төрийн хэлмэгдэгчдийг цагаатгуулах өргөдөл, гомдол хүлээж авах хуулийн хугацааг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгах шаардлагатай байна.

Үүнд:

1.1 Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө бүлгийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Монгол Улсад оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй” гэж, 14.2 дахь хэсэгт “хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “амьд явах эрхтэй, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” гэж, 16.12 дахь хэсэгт “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй” гэж, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд: түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалсан уриалгын 2 дугаар зүйлд “Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Мөн тухайн хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжид байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй” гэж, 3 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй” гэж, 5 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй” гэж, 7 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчлалаас болон тийнхүү алагчлахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй” гэж, 8 дугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” гэж, 9 дүгээр зүйлд “Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй” гэж, 10 дугаар зүйлд “Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй” гэж, 11 дүгээр зүйлийн 1 дүгээрт “Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй”, 2 дугаарт “Тухайн үед үндэсний буюу олон улсын хуулийн дагуу гэмт хэрэгт эс тооцож байсан аливаа үйлдэл буюу эс үйлдлийг үндэслэж, хэнийг ч гэмт хэрэгт яллан шийтгэх ёсгүй, гэмт хэрэг гарсан тэр үед ногдуулж болох байснаас илүү хүнд ял тохоож болохгүй” гэж тус тус заажээ.

Дээрх хууль зүйн үндэслэлүүдээр “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачилж байна.

1.2 Нийгэм, эдийн засгийн үндэслэл:

2018 оноос хойш Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд заасан журмын дагуу Тагнуулын ерөнхий газрын Тусгай архивын шалгагдаагүй хэргүүд, орон нутгийн архивуудаас татан төвлөрүүлсэн улс төрийн хэргүүд болон 1998 оноос хойш шинээр илэрсэн нөхцөл байдлаар хэрэг үүсгэн шалгаад, улс төрийн хилс хэрэгт холбогдсон гэх ямар нэгэн нотлох баримт тогтоогдоогүйгээс мөрдөн байцаалтыг зогсоосон хэргүүдийг сэргээж, мөн иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу шинээр илэрсэн нөхцөл байдлаар хэрэг үүсгэсэн нийт 1,289 хэргийг Улсын Прокурорын ерөнхий газар хянаж, прокурорын тогтоолоор 104 хэргийн 144 хүнийг, Улсын дээд шүүхэд

дүгнэлт бичсэнээр 68 хэргийн 79, нийт 223 хүнийг цагаатгаж, 1,146 хэргийн 1,400 орчим хүнийг цагаатгах үндэслэлгүй тул хэвээр буцаасан байна. Одоо 637 хэргийн 1000 орчим хүнд холбогдох үлдэгдэл хэргийг шалгаж дуусгах, цагаатгах, цагаатгуулах гомдол гаргах зэрэг асуудал хуулийн өөрчлөлтийн байдлаас хамааран зогсонги байдалд ороод байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр дээрх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д заасны дагуу Улсын комиссын жилийн ажлын тайланг авч хэлэлцээд 66/39 дүгээр зөвлөмж гарган цагаатгуулах өргөдөл хүлээн авах болон нөхөх олговор олгох хуулийн хугацааг 2 жилээр сунгах, энэ хугацаанд цагаатгадаагүй иргэдийн хэргийг шалгаж цагаатгах үүрэг өгсөн байдгаас одоогийн байдлаар:

1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас татан төвлөрүүлсэн 20 хэрэг, нийт 637 хэргийг бүрэн шалгаж шийдвэрлэх;

2. Улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаадсан иргэдийн материалыг татаж авах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Дээр дурдсан үндэслэл шаардлага болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжөөр өгсөн үүргийг хэрэгжүүлэхийн тулд хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хууль батлагдсанаар Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас татан төвлөрүүлсэн 20 хэрэг, нийт 637 хэргийг бүрэн шалгаж цагаатгах, улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаадсан иргэдийн материалыг татаж авах эрх зүйн орчин бүрдэж улс төрийн хэлмэгдүүлэлтийн улмаас нийгэмд учирсан хор хохирол, үүсэж бий болсон шалтгаан нөхцлийг тодорхойлох, хэлмэгдэгчдийг цагаатгах, нэр төрийг сэргээх, дурсгалыг мөнхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах болно.

Хоёр. “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1 “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл нь цагаатгуулах гомдлыг хүлээн авах хуулийн хугацааг сунгаж, тодорхой нөхцөл байдал, учир шалтгааны улмаас цагаатгуулж амжаагүй иргэдийн эрхийг хангах, эдгээр иргэдийн эрхзүйн асуудлыг шийдвэрлэх зорилготой юм.

2.2 Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

2.2.1 Өөрчлөлтийг “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуулийн хоёрдугаар бүлэг, 6 дугаар зүйлийн 6.3-т тусгана.

2.2.2 “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл нь нэг зүйлтэй байх бөгөөд дараах агуулгатай байна.

1/ Цагаатгуулах тухай гомдлыг оны дугаар сарын -ны өдрийн дотор гаргаж болох бөгөөд энэ хугацаанаас хойш гаргасан гомдлыг хүлээж авахгүй”

2.3 “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн хамрах хүрээ нь энэ хуулийн 2 дугаар бүлгийн 4 ба 5 дугаар зүйлд заасан “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч” гэж тооцогдох Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн байна.

2.4 “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч” өөрөө буюу түүний гэр бүлийн аль нэг гишүүн, хууль ёсны төлөөлөгч, түүнчлэн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, түүний орон нутгийн салбар комиссын хүсэлтээр цагаатгуулах үйл ажиллагаа явагдана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

“Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг баталж, мөрдүүлэх нь дараах үр дагавартай:

3.1 Монгол Улсын Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөө бүлэгт заасан хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байх нийгэм улс төрийн баталгааг хангана.

3.2 Хуулийн таатай орчин бүрдэж иргэдэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

3.3 Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн гэх иргэдийг нэг мөр цагаатгаж, нэр төрийг сэргээснээр улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг өөрийн биеэр мэдэрч бие махбодь, сэтгэл санааны хэлмэгдүүлэлтэд өртсөн хэлмэгдэгч болон дам хэлмэгдэлтэд өртөж сэтгэл санааны хохиролд хамгийн ихээр өртсөн түүний гэр бүлийн гишүүдийн гомдол шийдвэрлэгдэнэ.

3.4 Хуулийн өөрчлөлтөөр нөхөх олговортой холбогдох хуулийн зохицуулалт хөндөгдөхгүй тул Улсын төвлөрсөн төсөвт ямар нэг байдлаар дарамт, нөлөөлөл үүсэхгүй.

3.5 Сунгасан хугацаанд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд зааснаар хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, цагаатгагдсан иргэдийн дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх гэх мэт зохих ажлуудыг гүйцэтгэж нийгэмд хэлмэгдүүлэлтийн хор уршгийг таниулна.

3.6 Цагаатгуулах гомдлыг хүлээн авах хуулийн үйлчлэх хугацааг сунгаснаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн талаар гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

3.7 Хууль батлагдсанаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас татан төвлөрүүлсэн 20 хэрэг, нийт 637 хэргийг бүрэн шалгаж цагаатгагдах, улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаадсан иргэдийн материалыг татаж авах асуудлыг шийдвэрлэх боломжтой болно.

Дөрөв. Хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хэрхэн уялдах талаар болон, цаашид өөрчлөлт оруулах, хүчингүй болох хуулийн талаар

Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд нийцсэн байна. Уг хууль батлагдсанаар өөр бусад шинээр боловсруулах болон өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй байна.